



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-ЫН ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

ОРА-2021/92-ШТА-ГА



**ТӨСВИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МЭДЭЭЛЛИЙН ТОГТОЛЦООГ
БҮРДҮҮЛСЭН ХЭДИЙ Ч ЗАРЧИМ ХАНГАГДАХГҮЙ БАЙНА.**

**ОРХОН АЙМАГ
2021 ОН**



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/02

Эрдэнэт

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалын тавдугаар хавсралтаар батлагдсан Аймаг, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторов эрх үүргийн 2.4 дэх хэсэг, “Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгахаар өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ерөнхий захирал Х.Бадамсүрэнд зөвлөсүгэй.
5. Аудитын тайлангаар өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2021 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Б.Эрдэнэ/, ахлах аудитор /Б.Буян-Ундрах/, аудитор /Д.Цогбадрах/ нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Агуулга

Аудитыг гүйцэтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар	1
Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл, үндсэн мэдээлэл.	2
Аудитын менежер: Б.Эрдэнэ	БҮЛЭГ 1. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь хуульд заасан зарим мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.	5
Ахлах аудитор: Б.Буян-Ундрах Г.Оргилмөрөн	1.1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийн 66 хувийг хугацаанд нь мэдээлсэн байна.	5
Аудитор: Д.Цогбадрах Б.Азжаргал	1.2 Төсөв өмч хөрөнгө зарцуулах шийдвэрийг огт мэдээлэхгүй байна.	6
2021 оны 09 дүгээр сар	БҮЛЭГ.2 Хөрөнгө зарцуулахдаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй байна.	9
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70357955, 70350757 дугаарын утас, 70359826 дугаарын факсаар харилцана уу.	2.1 Хуулийн 6.4.8-д заасан мэдээлэлд агуулагдах төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрүүд холбогдох хууль тогтоомж, журамд нийцээгүй байна.	9
Уг тайланг УАГ-ын веб сайтаас үзнэ үү.	2.2 Хуулийн 6.4.3-д заасан мэдээлэлд агуулагдах хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зарим үйл ажиллагаа холбогдох хууль, журмын шаардлага хангаагүй байна.	11
www.audit.mn	БҮЛЭГ.3 Шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэн, аудитаар өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.	14
Хаяг: Орхон аймаг дахь Төрийн аудитын газар	3.1 Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Дотоод хяналтын хэлтэс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.	14
Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон	3.2 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.	15
	Аудитын дүгнэлт	16
	Аудитын зөвлөмж	17

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУ	Монгол улс
НББ	Нягтлан бодох бүртгэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТТХ	Төсвийн тухай хууль
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ХА	Харьцуулалтын арга
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШГ	Шууд гэрээ
ШДТХ	Шилэн дансны тухай хууль
ТББ	Тендерийн баримт бичиг

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны 02 сарын 18-ны өдрийн А/15 дугаар тушаалаар батлагдсан “Аудитын сэдэв батлах тухай”, 2021 оны 03 сарын 10-ны өдрийн А/28 тушаалаар батлагдсан аудитын төлөвлөгөөний дагуу, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт:

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийгдлээ. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх;
- Хуулийн 6.4-д заасан мэдээллүүдэд агуулагдах төсвийн зарцуулалт үр дүнтэй эсэх;
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлсэн эсэх;

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ыг хамруулан, 2020 оны шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд Орхон аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС-300, 3000-3100), Монгол Улсын Төрийн аудитын стандарт, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмыг баримтлан Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын мэдээллийн самбар болон цахим хуудаст байршуулсан мэдээллийг дансны хуулга, анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудиттай холбоотой дараах хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглав. Үүнд:

- Шилэн дансны тухай хууль
- Төсвийн тухай хууль

- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”,
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Шагналын ерөнхий журам,
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас тусламж, дэмжлэг үзүүлэх журам,
- Орон сууц хөлслүүлэх журам,
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.

Аудит хийж гүйцэтгэсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Нармандах хянан удирдаж, аудитын менежер Б.Эрдэнэ аудитын стандарт, арга зүйн дагуу хяналт тавьж, ахлах аудитор Б.Буян-Ундрах, Г.Оргилмөрөн, аудитор Д.Цогбадрах, Б.Азжаргал нар хийж гүйцэтгэв.

Аудитыг гүйцэтгэсэн хугацаа:

Аудитын талбарын ажлыг 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрөөс, тайлагналын үе шатны ажлыг 07 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн, тайланг 2020 оны 08 дугаар сарын 5-ны өдрийн дотор үе шатны хяналтаар оруулж, Тэргүүлэх аудитораар баталгаажуулж, 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн дотор Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т хүргүүллээ.

Үндсэн мэдээлэл:

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь зэс, молибдены хүдрийн олборлолт, баяжуулалтаар Ази тивдээ томоохонд тооцогддог үйлдвэр бөгөөд жилд 37 сая тонн хүдэр олборлон, 32 сая тонн хүдэр боловсруулж 580.0 орчим мянган тонн зэсийн баяжмал, 5.0 орчим мянган тонн молибдены баяжмал үйлдвэрлэдэг.

"Эрдэнэтийн-Овоо" ордыг анх 1963 онд Чех, Монголын геологичид нээж, уг орд газарт хайгуулын ажлыг гүйцэтгэсэн бөгөөд үргэлжлүүлэн Зөвлөлтийн геологичид орд газрын нарийвчилсан хайгуулыг богино хугацаанд хийж дуусгасан юм.

1972 онд "Эрдэнэтийн-Овоо"-ны зэс, молибдены ордыг эзэмших Техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ батлагдсан ба 1973 оны 2 дугаар сарын 20-нд уг ордыг ашиглах талаар /хуучин нэрээр/ БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газрын хооронд түүхэн хэлэлцээр байгуулагдсан.

Монгол-Зөвлөлтийн хамтарсан уул уурхайн баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр /хуучин нэрээр/ нь БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1973 оны 11 дүгээр сарын 22- ны өдрийн хэлэлцээрийн дагуу анх 50:50 хувийн эзэмшилтэйгээр байгуулагдаж, 1978 оны 12 дугаар сарын 14-нд анхны баяжмалаа гаргаснаар үйл ажиллагаагаа эхэлсэн тэр үеэс ХХ зууны Монгол Улсын хамгийн том бүтээн байгуулалт болох Эрдэнэт үйлдвэрийн түүх эхэлсэн төдийгүй уул уурхай дагасан, иж бүрэн дэд бүтэц бүхий Эрдэнэт хотыг цогцоор нь бүтээн босгосон нь уул уурхайн томоохон төслийн сонгодог загвар болсон юм.

Эрдэнэт үйлдвэр нь хоёр улсын Засгийн газар хоорондын 1991 оны хэлэлцээрийн дагуу 51:49 хувийн эзэмшилтэй хамтарсан үйлдвэр, 2003 оны хэлэлцээрийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/-ийн хэлбэрээр ажиллаж байгаад 2016 оны 6 дугаар сард ОХУ-ын “Ростех” корпораци өөрийн эзэмшлийн 49 хувийг худалдсанаар Монгол Улсын Засгийн газар 51 хувийг, “Монголиан коппер корпорейшн” ХХК 49 хувийг эзэмшиж байв.

Монгол Улсын Засгийн газар 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдөр тогтоол гаргаж, “Эрдэнэт үйлдвэр”-ийг Төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчилж, дүрмийг баталсан. Эрдэнэт үйлдвэр нь Улсын үйлдвэрийн газрын статустай болсонтой уялдуулж, Ерөнхий захирлын 2019 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн А/552 дугаар тушаалаар үйлдвэрлэлийн удирдлага, менежментийн тогтолцоо, үйл ажиллагааны зарчим, хөгжлийн төлөвлөлтийг хамарсан урт хугацааны “Тогтвортой хөгжлийн бодлого”-ыг баталсан. Энэ хүрээнд Технологийн бодлого, Техникийн бодлого, Эдийн засаг, санхүү бүртгэлийн бодлого, Нийгмийн бодлого, Байгаль орчны бодлого гэсэн тэргүүлэх 5 чиглэлийн хүрээнд 25 зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх.

Бүлэг 1 Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь хуульд заасан зарим мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.

1.1 Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийн 66 хувийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо /цаашид “шилэн данс” гэх/-г бүрдүүлэхэд оршино.”, 3 дугаар зүйлийн 3.1-д “Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна:”, 3.1.2-д “төрийн өмчит үйлдвэрийн газар;”, 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:”, 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;”, 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх;”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;”, 4.1.4-д “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх.” гэж заасан.

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээлбэл зохих 46 мэдээллээс 30 мэдээллийг хуулийн хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллүүдийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан байдлыг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	Нийт мэдээлэх тоо	Үүнээс:					
		Хугацаандаа мэдээлсэн тоо	Хугацаандаа мэдээлсэн хувь	Хугацаа хоцроож мэдээлсэн тоо	Хугацаа хоцроож мэдээлсэн хувь	Мэдээлээгүй тоо	Мэдээлээгүй хувь
Хуулийн 6.1.1 ¹ дэх заалт	2	2	100%	0	0%	0	0%
Хуулийн 6.1.2 ² , 6.1.6 ³ дахь заалтууд	16	1	6.25%	15	93.75%	0	0%

¹ тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;

² хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор;

³ төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр.

Хуулийн 6.1.3 ⁴ дахь заалт	25	25	100%	0	0%	0	0%
Хуулийн 6.1.4 ⁵ дэх хэсэг	2	2	100%	0	0%	0	0%
Хуулийн 6.1.5 ⁶ дахь хэсэг	2	1	50%	1	50%	0	0%
Нийт дүн	46	30	65%	16	35%	0	0%

Хуулийн 6.1.1, 6.1.2 дахь заалтуудын хүрээнд Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны "Худалдан авах ажиллагааны тайлан (Бүтэн жилээр)" талбарт мэдээлсэн худалдан авах ажиллагааны тайлангийн мэдээллийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2020 оны худалдан авах ажиллагааны ерөнхий тайлан /Маягт 3/ - ийн мэдээлэлтэй тулган шалгахад 19 худалдан авалтын 1,122,495.6 мянган төгрөгийн гэрээний дүн бүхий мэдээлэл дутуу мэдээлэгдсэн байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбар 15 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

1.2 Төсөв, өмч хөрөнгө зарцуулах шийдвэрийг огт мэдээлэхгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.2, 6.4.6, 6.4.7-д заасан мэдээллүүдийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан байдлыг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	Нийт мэдээлэх тоо	Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцроож мэдээлсэн	Мэдээлээгүй
6.4.1. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	12	12	0	0
6.4.2. Тухайн байгууллагын төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	12	12	0	0
6.4.6. Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	12	12	0	0
6.4.7. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	12	12	0	0
Нийт дүн	48	48	0	0
Хувь	100%	100%	0%	0%

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.2, 6.4.6, 6.4.7-д заасан 48 мэдээллийг 100 хувьтай мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.10-д заасан мэдээллүүдийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан байдлыг хүснэгтээр харуулбал:

⁴ дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор

⁵ жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор;


⁶ төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор;

6.4.3. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан			6.10. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл		
Тендер шалгаруулсан худалдан авах ажиллагааны тоо	мэдээлсэн тоо	мэдээлсэн хувь	Нийт мэдээлэх тоо	мэдээлсэн тоо	мэдээлсэн хувь
1463	1463	100%	2360	897	38%

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-т заасан тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл шалтгааныг бүрэн мэдээлсэн хэдий ч 3 болон 6 сарын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.10-т заасны дагуу үнэлгээний хороо байгуулах болгонд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай 897 мэдэгдлийг PDF форматаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан байна. Харин 1463 хуулийн этгээдтэй байгуулсан гэрээнд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг PDF форматаар байршуулаагүй байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл байршуулсан байдлыг графикаар харуулбал:



Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.8-д заасан мэдээллүүдийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан байдлыг хүснэгтээр харуулбал:

6.4.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл			6.4.8. Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл		
5 сая төгрөгөөс дээш нийт худалдан авалтын тоо	Үүнээс: Мэдээлээгүй худалдан авалтын тоо	Мэдээлээгүй хувь	Нийт шийдвэрийн тоо	Мэдээлээгүй тоо	Мэдээлээгүй хувь
1652	29	1.8%	362	362	100%


Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны "Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр)" талбарын мэдээллийг өссөн дүнгээр мэдээлэхдээ 17 худалдан авалтын санхүүжилтийн мэдээллийг 603,094.4 мянган төгрөгөөр зөрүүтэй, 3,982,434.9 мянган төгрөгийн санхүүжилтийн дүн бүхий 29 худалдан авалтын мэдээллийг дутуу, 1-4 сар болон 10 сарын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 362 мэдээллийг огт оруулаагүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан мэдээллүүдийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан байдлыг хүснэгтээр харуулбал:

6.4.5. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ			6.4.5. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ				
5 сая төгрөгөөс дээш нийт гүйлгээний тоо	Үүнээс: Мэдээлээгүй гүйлгээний тоо	Мэдээлээгүй хувь	5 сая төгрөгөөс дээш нийт гүйлгээний тоо	Үүнээс: Мэдээлээгүй гүйлгээний тоо	Мэдээлээгүй хувь	Үүнээс: Утга өөрчилсөн гүйлгээний тоо	Утга өөрчилсөн хувь
1639	1	0.06%	3526	119	3.4%	609	17.3%

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг графикаар харуулбал:



Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,270,318.2 мянган төгрөгийн 119 зарлагын мөнгөн гүйлгээ, 5,000.0 мянган төгрөгийн 1 орлогын мөнгөн гүйлгээг дутуу тайлагнасан байна. Мөн 1-4 сар болон 10 сарын мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн бол 609 зарлагын мөнгөн гүйлгээний утгыг өөрчилж мэдээлсэн байна.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасан мэдээллүүдэд агуулагдах төсвийн зарцуулалт үр дүнтэй байна уу.

Бүлэг 2 Хөрөнгө зарцуулахдаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй байна.

2.1 Шилэн дансны тухай хуулийн 6.4.8-д заасан мэдээлэлд агуулагдах төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрүүд холбогдох хууль тогтоомж, журамд нийцээгүй байна.

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирал төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 362 тушаал гаргасан байна. Эдгээр тушаалуудыг хууль тогтоомж, журамд нийцэж байгаа эсэхийг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1⁷, 16.11⁸ дэх хэсэг болон Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын шагналын ерөнхий журмын 1.2⁹-т заасныг тус тус зөрчин ерөнхий захирлын А/395 дугаар тушаалаар Орхон аймгийн Прокурорын газрын 6 ажилтныг 3,000.0 мянган төгрөгөөр, А/114 дүгээр тушаалаар Орхон аймгийн Цагдаагийн газрын даргыг 1,000.0 мянган төгрөгөөр, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн цагдааг 1,000.0 мянган төгрөгөөр тус тус шагнасан байна.
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Шагналын ерөнхий журмын 1.2-т "Хамрах хүрээ: Үйлдвэрийн газрын ажилтан, ахмад настан, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон иргэдэд энэхүү журам үйлчилнэ." гэж заасныг тус тус зөрчин ерөнхий захирлын А/327 дугаар тушаалаар "Шарын гол" ХК-ын 5 ажилтныг 2,500.0 мянган төгрөгөөр, А/368 дугаар тушаалаар Улаанбаатар төмөр зам ХНН-ийн 11 ажилтныг 5,500.0 мянган төгрөгөөр тус тус шагнасан байна.
- Ерөнхий захирлын А/389 дүгээр тушаалаар аймгийн баяр наадамд амжилт гаргасан Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 7 ажилтныг 8,610.0 мянган төгрөгөөр шагнасан байна. Баяр наадамд амжилт гаргасан ажилтныг шагнах талаар Шагналын ерөнхий журамд зааж өгөөгүй байна.

⁷ Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бусдаас бэлэг шууд буюу шууд бусаар авахыг хориглоно.

⁸ Мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх шагналыг энэ хуулийн 16.1-16.10-т заасан журмаар зохицуулна.

⁹ Хамрах хүрээ: Үйлдвэрийн газрын ажилтан, ахмад настан, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон иргэдэд энэхүү журам үйлчилнэ.

- Эрдэнэт үйлдвэрт 8 жил 5 сар ажиллаж байсан ахмад настны эмчилгээнд зориулж Ерөнхий захирлын А/335 дугаар тушаалаар 3,000.0 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас тусламж, дэмжлэг үзүүлэх журмын 5.1¹⁰ дэх хэсгийг зөрчсөн байна.
- Ерөнхий захирлын тушаалуудаар Шагналын ерөнхий журмын 2.1.10, 2.1.12 дахь заалтуудыг үндэслэл болгон нэр бүхий 52 ажилтныг 2 удаа нийт 229,800.0 мянган төгрөгөөр, 5 ажилтныг 3 удаа нийт 42,000.0 мянган төгрөгөөр шагнасан байна. Энэ нь шагналын ерөнхий журмын 8.2-д “Энэхүү журмын 2 дугаар бүлэгт заасан шагналыг давхардуулан олгохгүй.” гэсэн хэсгийг зөрчсөн байна.
- Анхан шатны баримтын бүрдэл хангаагүй гадаад, дотоод албан томилолтын төлбөр тооцоог хийсэн байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.1¹¹, 13.7¹² дахь хэсэг, Үйлдвэрийн захирлын 2019 оны 12 дугаар сарын 31-ний А/1220 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т ажиллаж байсан 15 ахмад настан, гаднын 6 нийт 21 иргэнд орон сууц хөлслүүлсэн байна. Энэ нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ерөнхий захирлын 2020 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн А/340 дүгээр тушаалаар батлагдсан Орон сууц хөлслүүлэх журмын 2.1¹³ дахь хэсгийг зөрчсөн байна.
- Монгол Улсаас Оросын холбооны Улсад суугаа Элчин сайдын яамны эзэмшлийн орон сууцуудын их засварын ажилд 10,000 (арван мянга) ам.доллар буюу тухайн үеийн ханшаар 28,054.1 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 25.10¹⁴ дахь хэсгийг зөрчсөн байна.
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын өмчид бүртгэлтэй ЭКО хорооллын 50-113 м² тайлбай бүхий 10 орон сууцыг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр, ямар нэгэн гэрээгүй ашиглуулж /шагнаж, бэлэглэсэн/ байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30.3¹⁵, 28.5¹⁶ дахь хэсгүүдийг зөрчсөн байна.

Дээрх 331,201.2 мянган төгрөгийн 9 зөрчилд хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрөлгүйгээр Ардын хувьсгалын 99 жилийн ойн байр наадмаар түрүүлсэн ажилтныг 2 өрөө орон сууцаар шагнасан

¹⁰ Үйлдвэрийн газарт хөдөлмөрийн гэрээгээр 10 ба түүнээс дээш жил ажилласан ажилтан, ахмад настан, ҮО, ХХ, МШӨ-ний улмаас ХЧА-ын хувь тогтоолгосон ажилтанд болон түүний гэр бүлийн гишүүний (эхнэр, нөхөр, хүүхэд) эмчилгээний зардалд эмчилгээний санхүүгийн тусламжийг нэг удаа олгоно.

¹¹ анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6-д “анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.

¹² анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

¹³ Орон сууцны сан нь үйлдвэрийн газрын ажилтан болон гадаад, дотоодын мэргэжилтнийг гэрээний дагуу орон сууцаар хангахад зориулагдана.

¹⁴ Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно.

¹⁵ Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно.

¹⁶ Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна. Уг төлбөр тухайн эд хөрөнгийг худалдан авах үнийн төлбөрт үл хамаарна.

байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30.3¹⁷ дахь хэсгийг зөрчсөн байна.

- Ерөнхий захирлын А/264 дүгээр тушаалаар 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг цаг хугацаанд нь бэлтгэсэн гэж нийт 129 ажилтанд 484,000.0 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын цалин хөлсний тухай журмын 4.1-д “Үйлдвэрийн газрын болон тухайн бүтцийн нэгжийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд хамт олон, ажилтны оруулж буй хувь нэмэр, ажлын гүйцэтгэл, үр дүн, идэвх зүтгэлийг бодитоор үнэлж, ажилтнуудыг идэвхжүүлэх зорилгоор сар бүрийн ажлын үр дүнгийн урамшуулал, жилийн ажлын үр дүнгийн урамшуулал олгоно.”; “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ажилтанд онцгой даалгавар гүйцэтгэсний үр дүнгээр урамшуулал олгох журмын журмын 1.3-д “Онцгой даалгавар гэдэгт: Үйлдвэрийн газрын найдвартай, тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах, эдийн засгийн үр өгөөж, бүтээмжийг нэмэгдүүлэхэд мэргэжлийн өндөр ур чадвар шаардсан ажлыг цаг хугацаа, санхүү, эдийн засгийн хувьд гаднын байгууллага болон хувь хүмүүсээр гүйцэтгүүлэхээс илүү үр дүнтэй, бага зардлаар хэмнэлттэй, чанартай гүйцэтгэх, үйлдвэрийн газарт их хэмжээний хохирол, аюул учруулахаас урьдчилан сэргийлэх, нийтийг хамарсан давагдашгүй хүчин зүйл, үндсэн технологийн процессын ноцтой доголдлыг түргэн шуурхай арилгах, үүнтэй холбоотой бусад ажлуудыг ойлгоно.”; шагналын ерөнхий журмын 8.2-д “Энэхүү журмын 2 дугаар бүлэгт заасан шагналыг давхардуулан олгохгүй.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна

Дээрх 578,000.0 мянган төгрөгийн 2 зөрчилд холбогдох албан тушаалтнуудад албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

- Ерөнхий захирлын тушаалаар 2020 оны 8, 9 саруудад сахилгын шийтгэл ногдуулсан 6 ажилтанд 12 сард 3,500.0 мянган төгрөгийн шагнал, урамшуулал олгосон байна. Энэ нь үйлдвэрийн Хөдөлмөрийн дотоод журмын 8.11¹⁸, Шагналын ерөнхий журмын 8.1¹⁹ дэх хэсгийг тус тус зөрчсөн байна.

Дээрх 3,500.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоохоор болов.

2.2 Шилэн дансны тухай хуулийн 6.4.3-д заасан мэдээлэлд агуулагдах хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зарим үйл ажиллагаа холбогдох хууль, журмын шаардлага хангаагүй байна.

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТӨБЗГ-ын 2019 оны 12 сарын 10-ны өдрийн 511 дүгээр тогтоолоор батлуулж, батлагдсан төлөвлөгөөнд үндэслэн 2020 оны худалдан авалтын төлөвлөгөөг боловсруулж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдөр байршуулсан байна.

¹⁷ Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно.

¹⁸ Сахилгын шийтгэл ногдуулсан хугацаанд буюу сахилгын шийтгэлгүйд тооцогдох хүртэл ажилтныг аливаа шагнал урамшуулалд хамруулахгүй.

¹⁹ Тухайн жилд хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсан буюу сахилгын шийтгэлгүйд тооцох хүртэл хугацаанд ажилтныг аливаа шагнал урамшуулалд хамруулахгүй

2020 онд тендерийн үнэлгээний хороо байгуулах тухай ерөнхий захирлын 36 тушаал, ажлын хэсэг байгуулах тухай ерөнхий захирлын санхүү, эдийн засаг хариуцсан орлогчийн 15 шийдвэр зэрэг нийт 1291 үнэлгээний хороо, ажлын хэсэг байгуулан ХАА-г зохион байгуулсан байна.

2020 онд нийт 987.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 893.0 тэрбум төгрөгийн дүнтэй 1463 гэрээ байгуулсан байна.

НТШ-аар 656.9 тэрбум төгрөгийн 643 гэрээ, тендер шалгаруулах онцгой журмын харьцуулалтын аргаар 17.7 тэрбум төгрөгийн 552 гэрээ, тендер шалгаруулах онцгой журмын хязгаарлагдмал тендерийн аргаар 13.8 тэрбум төгрөгийн 8 гэрээ, тендер шалгаруулах онцгой журмын гэрээ шууд байгуулах аргаар 192.1 тэрбум төгрөгийн 108 гэрээ, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмаар 7.9 тэрбум төгрөгийн 28 гэрээ, зөвлөхөөс бусад үйлчилгээний 0.8 тэрбум төгрөгийн 1 гэрээ, шууд худалдан авалтын аргаар 0.7 тэрбум төгрөгийн 123 худалдан авалтыг зохион байгуулсан байна.

ХАА-ны төлөвлөгөөг 292 бараа, ажил үйлчилгээгээр нэмэгдүүлж, Сангийн яаманд хүсэлт хүргүүлж, ТӨБЗГ-ын баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тодотгосон байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 48.1, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалын 1-р хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.1, 2.5, 2.14 дэх хэсгүүдтэй тус тус нийцэхгүй байна.

Аудитаар тендер, худалдан авалтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг түүвэрлэн аудит хийхэд дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- "Эрдэнэтийн цэвэрлэх байгууламжийн хуримтлагдсан лагийг гумины болон био бэлдмэл ашиглан үнэргүйжүүлэх, боловсруулах ажил" нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 11.2, 34.2, 45.1, 46.1.4, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалын 1-р хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.1, 2.5, 2.14 дахь хэсгүүдтэй тус тус нийцэхгүй байна.
- Ерөнхий захирлын 2020.01.27-ны өдрийн А/47 дугаар тушаалын хүрээнд зарим барааны худалдан авалтууд ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34.1.5 дахь заалтын хүрээнд гэрээ шууд байгуулах аргаар зохион байгуулагдсан бөгөөд тэдгээрээс дараах худалдан авалтууд нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 6.1, 34.2 дахь хэсэгтэй нийцэхгүй байна. Үүнд:
 1. Нэг удаагийн амны хаалт 90.0 мянган ширхгийг нэг бүрийг 700 төгрөгөөр буюу нийт 63,000.0 мянган төгрөгөөр худалдан авахаар 2020.05.26-ны өдөр гэрээ байгуулсан. /Бараа нийлүүлэх хугацаа 15 хоног, тус компанийн үйл ажиллагааны чиглэл нь цайны газар, гадаад худалдаа, хаяг: Орхон аймаг, Баян-Өндөр, 1-р баг/.
 2. Ариутгал, халдваргүйтгэлийн бодис, хэрэгслийг 49,544.0 мянган төгрөгөөр худалдан авахаар 2020.03.13-ны өдөр гэрээ байгуулсан. /Бараа нийлүүлэх хугацаа 20 хоног, үйл ажиллагааны чиглэл нь 2021.05.14-нд бүртгэгдсэн,

2020.03.30-нд хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирлын мэдээлэл бүртгэгдсэн, хаяг: Улаанбаатар, Хан-Уул, 4-р хороо/.

3. Нэг удаагийн амны хаалт 200.0 мянган ширхгийг нэг бүрийг 220 төгрөгөөр буюу нийт 44,000.0 мянган төгрөгөөр худалдан авахаар 2020.12.31-ны өдөр гэрээ байгуулсан. /Бараа нийлүүлэх хугацаа 45 хоног, үйл ажиллагааны чиглэл оёдлын үйлдвэрлэл, сав, баглаа боодлын үйлдвэрлэл, худалдаа, хаяг: Улаанбаатар, Баянзүрх, 26-р хороо/

Дээрх зөрчлүүдэд хууль, тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлсэн эсэх.

Бүлэг 3 Шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэн, аудитаар өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3.1 Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Дотоод хяналтын хэлтэс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Үйлдвэрийн Дотоод аудитын хэлтэс нь Эрдэнэт үйлдвэр ХХК-н Ерөнхий захирлын 2007 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 69 дүгээр тушаалын дагуу, компанийн удирдлагын үр ашигтай үйл ажиллагааг хангах, цех нэгжүүдийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, үр ашгийг дээшлүүлэх, компанийн санхүүгийн чадавхыг бэхжүүлэхэд туслалцаа үзүүлэх зорилгоор байгуулагдаж, Ерөнхий захирлын Эдийн засаг эрхэлсэн орлогчийн харьяанд үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

Эрдэнэт үйлдвэр ХХК нь “Төрийн өмчит үйлдвэрийн газар” болсонтой холбогдуулж Дотоод аудитын хэлтсийн хараат бус байдлыг бүрэн хангахуйц байдлаар шинэчлэн зохион байгуулж, үйлдвэрийн газрын үнэ цэнийг нэмэгдүүлэх, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бүрдүүлэх, засаглал ба дотоод хяналтыг сайжруулахад туслах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах зорилгоор Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 88 дугаар тогтоол, Ерөнхий захирлын 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/244 дүгээр тушаалаар Дотоод хяналтын хэлтэс болгон өөрчлөн, бүтэц орон тоог шинэчлэн, үйлдвэрийн Ерөнхий захирлын шууд удирдлагад шилжүүлсэн байна.

Дотоод хяналтын хэлтсийн зорилго нь үйлдвэрийн газрын эрхэм зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд бүтцийн нэгжүүдийн тухайн жилийн зорилтыг хангахад хэрэгжүүлж буй үйл ажиллагаа болон түүнд учирч болзошгүй эрсдэлийг бууруулахад авч буй арга хэмжээнүүд, дотоод хяналтын хэрэгжилт, санхүүгийн болон бусад нөөцийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтын нөхцөл байдалд хяналтыг гүйцэтгэн үүссэн нөхцөлд дүн шинжилгээг хийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулан үнэн, бодит мэдээллээр удирдлагыг хангахад чиглэгдэнэ.

Үйлдвэрийн дотоод хяналтын хэлтэс 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ШДНЦХ-д 2021 оны 02 сарын 01-ны өдрөөс 02 сарын 29-ны өдрийн хооронд хяналт шалгалт хийсэн ба санхүү, нягтлан бодох бүртгэлийн

хэлтэст 2021 оны 05 сарын 13-ны өдөр ажлын тайланг хүргүүлсэн байна. Тухайн тайлангаар дараах дүгнэлтийг гаргасан байна. Үүнд:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуульд заасны дагуу 2020 онд 18 төрлийн 146 мэдээлэл байршуулсан. Хуулийн хугацаа хоцорсон 31 мэдээллийн 10 нь санхүүгийн Ера программаас зарим гүйлгээний мэдээллийн харилцагч байгууллагын нэр 0 утгатай татагдсанаас, 1 мэдээлэл аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээлэл байршуулах хуульд заасан хугацаанаас хоцорч гарсантай холбоотой, 5 мэдээлэл ажилтны хариуцлагагүй байдлаас, 15 мэдээлэл үйлдвэрийн газрын өртөг зардал сар бүр хуулийн хугацаа хоцорч гардагтай холбоотой байна.
2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэл байршуулсны дараа 33 удаа засвар өөрчлөлт оруулсан байна.
3. Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны бусад цэсэд хамаарагдах нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг тухай бүр мэдээлэх ёстой боловч хуулийн хугацаанд бүрэн мэдээлээгүй байна.
4. Шилэн дансны тухай хуулийн 2019 оны хэрэгжилт болон 2020 онд өгөгдсөн зөвлөмж 100 хувь биелсэн байна.

Дотоод хяналтын хэлтсийн тайлангаар ШДНЦХ-д 31 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг дутуу мэдээлсэн, 2019 болон 2020 өгөгдсөн зөвлөмжүүд 100 хувь биелсэн байна гэж дүгнэжээ.

“Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” гүйцэтгэлийн аудитаар ШДНЦХ-д мэдээлбэл зохих 6,380,248.7 мянган төгрөгийн 1993 ширхэг мэдээллийг дутуу байршуулсан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 609 зарлагын мөнгөн гүйлгээний утгыг өөрчилж, 17 худалдан авалтын санхүүжилтийн мэдээллийг 603,094.4 мянган төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн зэрэг зөрчил илэрсэн.

Дээрх дүгнэлтээс харахад үйлдвэрийн Дотоод хяналтын хэлтэс нь Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3.2 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2020 онд хийгдсэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захиралд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээллийг тогтоосон хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн, тогтмол, шуурхай мэдээлж байх гэсэн зөвлөмжийг өгсөн боловч зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийн 66 хувийг хугацаанд нь мэдээлсэн байна.
- Төсөв өмч хөрөнгө зарцуулах шийдвэрийг огт мэдээлэхгүй байна.
- Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрүүд холбогдох хууль тогтоомж, журамд нийцээгүй байна.
- Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зарим үйл ажиллагаа холбогдох хууль, журмын шаардлага хангаагүй байна.
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Дотоод хяналтын хэлтэс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ


“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ерөнхий захиралд:

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд үнэн зөв, бодитой, иж бүрэн, тогтмол, шуурхай мэдээлж байх.
2. Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг тухай бүр нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлж байх.
3. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тайлагнахдаа гүйлгээний утгыг өөрчлөлгүй, иж бүрэн мэдээлж байх.
4. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой мэдээллүүдийг бүрэн гүйцэд, цаг хугацаанд нь мэдээлж байх.
5. Шагналын ерөнхий журмын үйлчлэх хүрээнд ажилтан, албан хаагчдыг шагнаж байх.
6. Шагналын ерөнхий журмын 2 дугаар бүлэгт заасан шагналуудыг давхардуулан олгохгүй байх.
7. Төсвийн тухай хуулийн 25.10 дахь заалтыг мөрдөж, хандив, тусламж өгөхгүй байх.
8. Тусламж дэмжлэг үзүүлэх журмын 5.1 дэх заалтыг мөрдөж, Эрдэнэт үйлдвэрт хөдөлмөрийн гэрээгээр 10 ба түүнээс дээш жил ажилласан ахмад настанд эмчилгээний санхүүгийн тусламжийг олгож байх.
9. Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, гадаад, дотоод албан томилолтын төлбөр тооцоог хийхгүй байх.
10. Орон сууц хөлслүүлэх журмыг мөрдөж, үйлдвэрийн газрын ажилтан, гадаад, дотоодын мэргэжилтнүүдээс бусад этгээдэд төрийн өмчийн орон сууцыг хөлслүүлэхгүй байх.
11. ТБОНӨХБАҮХАТ хуулийг чанд мөрдөж, худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлах.
12. Дотоод хяналтын хэлтэс нь ШДТХ-ын хэрэгжилтэд тавих хяналтыг тогтмол, үр дүнтэй, бодит цагт хэрэгжүүлж байх.

ТАЙЛАН ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:  Б.ЭРДЭНЭ

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР:  Б.БУЯН-УНДРАХАУДИТОР:  Д.ЦОГБАДРАХ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”

ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

61027 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Найрамдал талбай,

Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,

И-мэйл: info@erdenetmc.mn, Вэбсайт: www.erdenetmc.mn

2021. 08. 13 № 515-111-12/4424

танай _____-ны № _____-т

Шилэн дансны аудитын тайлангийн
төсөлд санал хүргүүлэх тухайОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2020 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд өгөх хариу саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт¹⁶ хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Х.БАДАМСҮРЭН

610410213090